



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/219

Есөнбулаг сум

Эрсдэлийн харилцаа холбооны баг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам"-ын 3.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон нийттэй харилцах Эрсдэлийн харилцаа холбооны багийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Эрсдэлийн харилцаа холбооны тайван цагийн болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн төлөвлөгөө, заавар, журмыг батлан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

3.Эрсдэлийн харилцаа холбооны багийн гишүүдийг чадавхжуулах, салбар хоорондын хамтын ажиллагаа, сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн оны төсөвт тусгаж ажиллахыг Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч бөгөөд Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 13-ны өдрийн А дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэлийн харилцаа холбооны багийн бүрэлдэхүүн нь Монгол улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа холбооны удирдамж"-ийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Багийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч Багийн зохицуулагч: Тухайн болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрлөөс хамаарч Монгол улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ын 4.1.2-т заасан тэргүүлэх чиглэлийн байгууллагын аймгийн түвшний байгууллагын төлөөлөл

Багийн гишүүд:

- (Мал эмнэлгийн газрын дарга)
- (Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)
- (Хүнс хөдөө аж ахуйн газрын хяналтын хэлтсийн дарга)
- (Зоонозын өвчин судлалын төвийн дарга)
- (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн)
- (Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)
- (Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч)
- (Зоонозын өвчний судлалын төвийн тархвар судлагч их эмч)
- (Мал эмнэлгийн газрын зооноз халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн)
- (Эрүүл мэндийн газрын сургалт, сурталчилгаа мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)
- (Мал эмнэлгийн газрын өвчний мэдээ, тайлан хариуцсан мэргэжилтэн)
- (Байгаль орчны газрын зэрлэг ан амьтан хариуцсан мэргэжилтэн)
- (Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга)
- (Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцан зөвшилцсөнөөр)
- (Алтай радио, Миний нутаг, Алтай телевиз)

Нарийн бичгийн дарга:

- (Эрүүл мэндийн газрын тархвар судлаач мэргэжилтэн)

